



# Сарлагийн хөөврийн дэд салбарын нэмэгдсэн өртөгийн сүлжээний шинжилгээний тайлан

Тайланг нэгтгэсэн:

Д. Эрдэнэбилэг, Баянхонгор аймгийн Мэдээллийн ажилтан  
Т. Түмэнбаясгалан, Өвөрхангай аймгийн Мэдээллийн ажилтан  
М. Ариунбат, Архангай аймгийн Хөтөлбөрийн ажилтан  
Ш. Сарангэрэл, Завхан аймгийн Хөтөлбөрийн ажилтан  
А. Солонго, ХАБДХ-ийн ЗЗХ-ийн ажилтан,  
Ч. Баярмаа, ГС хөтөлбөрийн ЗЗХ-ийн ажилтан

2008.03.06

## Агуулга

1.	Танилцуулга.....	3
2.	Судалгааны ажлын зорилго .....	4
3.	Судалгааны баг.....	4
4.	Судалгааны ажлын хамрах хүрээ .....	5
5.	Сонгосон аймгиудын сарлагийн хөөврийн салбарын товч танилцуулга .....	5
6.	Судалгааны арга зүй .....	6
7.	Судалгааны нэгтгэл, үр дүн .....	7
8.	Сарлагийн хөөврийн салбарын өртөгийн сүлжээний зураг.....	10
9.	Сарлагийн хөөврийн дэд салбарын зураглалтай холбогдуулан хийх дүгнэлтүүд .....	11
	• Сарлагийн хөөвөр үйлдвэрлэн борлуулж буй үндсэн сувгууд.....	11
	• Сарлагийн хөөврийн бэлтгэлийн боломжит хэмжээ .....	12
	• Сарлагийн хөөврийн дэд салбарын бэрхшээл ба боломжит шийдлүүд .....	13
	• Боломжит шийдлүүдийн үнэлгээ .....	15
	• Үр нөлөө бүхий шийдлүүдийг хэрэгжүүлэхэд Хөтөлбөрийн оролцоо .....	19
10.	Дүгнэлт.....	20

## 1. Танилцуулга

Сарлаг нь өндөр уулын бүсэд амьдардаг хүйтэн сэрүүн нөхцөлд зохицсон омголон догшин амьтан бөгөөд Дэлхийд Хятад, Монгол, Энэтхэг, Балба, Бутан, Орос, Пакистан зэрэг арав хүрэхгүй оронд сарлаг өсгөн үржүүлдэг ба эдгээр оронд өнөөгийн байдлаар нийт 10 гаруй сая толгой сарлаг байдаг байна. Сарлагийн тоогоороо БНХАУ тэргүүн эгнээнд жагсдаг буюу Дэлхийн нийт сарлагийн 85 хувь нь Хятадад байна. Харин манай улс сарлагийн тоо толгойгоороо хоёрдугаарт орох ба манай орны Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар буюу Архангай, Завхан аймгийн зүүн болон урд сумд, Өвөрхангай аймгийн хойд сумд, Баянхонгор аймгийн хангайн буюу хойд, баруун хойд сумдаар өргөн тархсан байдаг. Монгол Улс 1999 онд 800 мянга гаруй сарлагтай байсан бол 2004 оны жилийн эцсээр 400 гаруй мянгахан толгой болж цөөрчээ. Харин 2006 оны эцсийн байдлаар 536,5 мянган тоо толгой сарлаг тоологдсон байдаг бөгөөд сүүлийн 5 жилийн статистик мэдээнээс харахад сарлагийн тоо толгой өсөх хандлагатай байна.

### Хүснэгт 1. Сарлагийн тоо толгой

№	Аймаг	2002	2003	2004	2005	2006
1	Архангай	103,984	112,253	111,640	122,185	142,089
2	Баянхонгор	66,088	69,113	72,513	77,374	87,092
3	Завхан	38,458	40,750	43,378	48,980	57,000
4	Өвөрхангай	40,600	53,400	56,300	57,800	58,900
<b>Нийт</b>		<b>249,130</b>	<b>275,516</b>	<b>283,831</b>	<b>306,339</b>	<b>345,081</b>
Өсөлт			10.6%	3.0%	7.9%	12.6%

Сарлагийн мах, сүүг одоогоор өргөн хэрэглэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд сарлагийн хөөврөөр бэлэн болон сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсноор сарлагийн хөөврийн эрэлт шинээр эрчимтэй гарч ирч байна. Сарлагийн хөөврөөр хийсэн сүлжмэл бүтээгдэхүүн нь чанарын хувьд ямааны ноолууран бүтээгдэхүүнтэй эн зэрэгцэх бөгөөд дотоодын зах зээлд нийлүүлэгдэж байна.

**Бусад төсөл хөтөлбөрүүдээс Монголын Сарлагийн аж ахуйн өнөөгийн хөгжил, ялангуяа хөөврийн талаар юу хийсэн бэ?**

- Одоогоор сарлагийн хөөврийн ашиглалт, бэлтгэн нийлүүлэлт, хэрэглээний талаар Засгийн газраас болон бусад төсөл хөтөлбөрүүдээс ямар нэгэн дорвитой үйл ажиллагаа явуулаагүй хэвээр байна. Бидний мэдэж байгаагаар "Монгол Сарлаг" нийгэмлэг нь сүүлийн 2 жилд Швецарын Хөгжлийн Агентлагаас санхүүжигдэн хэрэгжиж байгаа "Ногоон Алт" хөтөлбөртэй хамтран сарлагийн ашиг шимийг нэмэгдүүлэх, ялангуяа сарлагийн хөөврийн ашиглалтыг нэмэгдүүлэх талаар нилээд зүйл хийгээд байгаа бөгөөд 2008 оноос Мерси Кортой хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд сарлагийн хөөврийг самнаж бэлтгэх талаар сургалт явуулах, мөн үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар төлөвлөөд байна.
- 2007 оноос "Ирвэс" Сангаас Баянхонгор, Өвөрхангай, Говь Алтай аймгуудын Говийн сумдын ирвэстэй нутгуудад амьдардаг сарлаг бүхий цөөн тооны малчин өрхүүдэд болон хангайн сумдын сарлаг ихтэй малчин өрхүүдэд "Сарлагийн хөөвөр самнах арга технологи зааж сургасан. Хэдийгээр эдгээр өрхүүд сарлаг самнах арга барилтай болж зарим нэг нь сарлагаа самнасан боловч борлуулах зах зээлээ мэдэхгүй мөн тэрчлэн үйлдвэрлэгчид ирж аваагүй учраас энэ ажил үр дүн муутай өнгөрсөн.

## Хүснэгт 2. Сарлагийн хөөвөр бэлтгэх боломж

№	Аймаг	Нийт малын тоо*	Үүнээс сарлагийн тоо*	Сарлагтай малчин өрхийн тоо	Нэг сарлагаас авах сарлагийн хөөвөр	Нийт бэлтгэх боломжтой сарлагийн хөөвөр, кг
1	Архангай	316,320	155,294	15356	300 гр	42,627
2	Баянхонгор	108,865	87,092	5,018	300 гр	26,128
3	Завхан	146,900	57,000	4,507	360 гр	20,520
4	Өвөрхангай	111,112	58,900	60,683	630 гр	37,107
	<b>Нийт</b>	<b>683,197</b>	<b>345,081</b>	<b>85,564</b>		<b>126,381</b>

\* 2006 оны байдлаар

Хэдийгээр 126,4 тонн сарлагийн хөөвөр нэг жилд бэлтгэх боломжтой ч өнгөрсөн жил 10,0 тонн сарлагийн хөөвөр бэлтгэсэн байна. Сарлаг самнах нь хугацаа их шаарддаг, хэцүү ажил бөгөөд самнасан хөөврийн үнэ хямд тул малчид хяргаж авахыг илүүд үздэг байна. Хяргасан хөөврийг эсгийний үйлдвэрүүд бага хэмжээгээр кг-ыг нь 400-500 төгрөгөөр авдаг бол малчид гэрийн хошлон, бүс хийх зэрэг ахуйн зориулалтаар ашигладаг байна.

Сарлагийн самнасан хөөврийн гол зах зээл бол дотоодын үйлдвэрлэгчид юм. Дотоодын үйлдвэрлэгчид ихээхэн хэмжээгээр боломжийн үнээр худалдан авч заншвал сарлагийн хөөврийн нийлүүлт нэмэгдэх бүрэн бололцоотой. 2006 онд 6 сард анх удаагаа сарлагийн хөөврийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад бэлтгэн нийлүүлэгчээр Архангай аймгийн Их тамир сумын малчид харин худалдан авагчаар Говь компани оролцож сарлагийн самнасан хөөврийн үнэ зах зээлд анх удаагаа 2500 төгрөгийн үнэ хүрч малчдын анхаарлыг зүй ёсоор татаж эхэлсэн. Боломж мэдээллийн хүртээмж муутай байдлаас шалтгаалан бусад сарлагтай аймгуудын малчид сарлагийн хөөврөө борлуулахгүй хэвээр байна. Гэвч Архангай аймагт байдал харьцангуй сайжирсан бөгөөд өнгөрсөн 2007 онд дахин үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж нийт 13 сумын малчид оролцсон бол худалдан авагч үйлдвэрлэгчдийн тоо нэмэгдэж Говь, Гоёо, Эрдэнэт зэрэг үйлдвэрлэгчид оролцож сарлагийн хөөврийн үнэ 2500-3500 төгрөг болж өссөн байна. Эндээс харахад үйлдвэрлэгчдийн зүгээс энэ бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгааг харж болно. Өнгөрсөн онд 10 гаруй тонн сарлагийн хөөвөр бэлтгэгдэж зах зээлд нийлүүлэгдсэнээс зөвхөн Архангай аймагт зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдааны үеэр 3,650 кг сарлагийн самнасан хөөвөр худалдаалагдаж малчид 12.7 сая төгрөгийн бэлэн мөнгөөр ашиг орлогоо нэмэгдүүлсэн байна.

## 2. Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны гол зорилго нь:

- Сарлагийн хөөврийн дэд салбарын оролцогчдыг тодорхойлох
- Тухайн дэд салбарт оролцогчдод тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх
- Тогтвортой үр нөлөө өгөх зах зээлийн шийдлүүдийг тодорхойлох
- Уг шийдлүүдийг хэрэгжүүлэх замаар сарлагийн хөөврийн дэд салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах

## 3. Судалгааны баг

Судалгааны баг нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа:

- Архангай аймаг - Үнэнбат, ЗСА, М. Ариунбат, Хөтөлбөрийн ажилтан
- Завхан аймаг - Ш. Сарангэрэл, Хөтөлбөрийн ажилтан
- Өвөрхангай аймаг - Т. Түмэнбаясгалан, Мэдээллийн ажилтан
- Баянхонгор аймаг - Д. Эрдэнэбилэг, Мэдээллийн ажилтан, Фахад Рэяз, СДА
- Улаанбаатар - А. Солонго, ХАБДХ-ийн ЗЗХ-ийн ажилтан, Ч. Баярмаа, ГС хөтөлбөрийн ЗЗХ-ийн ажилтан

#### 4. Судалгааны ажлын хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь Архангай, Завхан, Өвөрхангай, Баянхонгор аймгийн сарлаг ихтэй дараах сумдыг сонгон авсан болно.

- Архангай аймаг: Хангай, Чулуут, Ихтамир, Жаргалант, Тариат, Өндөр Улаан
- Завхан аймаг: Тэлмэн, Идэр, Тосонцэнгэл, Их уул, Алдархаан, Отгон, Шилүүстэй
- Өвөрхангай аймаг: Бат-Өлзий, Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт
- Баянхонгор аймаг: Галуут, Жаргалант, Гурванбулаг, Заг, Баянбулаг, Баянхонгор

#### 5. Сонгосон аймгиудын сарлагийн хөөврийн салбарын товч танилцуулга

- Архангай аймаг

Архангай аймаг нь 155,000 гаруй сарлагтай бөгөөд тус аймгийн Ихтамир, Чулуут, Хангай, Тариат, Өндөр-Улаан сумд нь сарлагийн хөөврийн гол нийлүүлэгч төдийгүй сайн чанарын хөөвөр бэлтгэх гол бааз суурь бүхий бүс нутаг юм. Нийт үхэр сүргийн 85% нь сарлаг байдаг ба жилдээ 42,6 тонн хөөвөр бэлтгэх нөөц боломжтой юм.

- Баянхонгор аймаг

Баянхонгор аймаг нь 108,865 орчим үхэртэй бөгөөд үүнээс 87,092 сарлаг 2006 онд тоологдсон юм. Тус аймгийн Эрдэнэцогт, Галуут, Заг, Жаргалант, Баянбулаг, Гурванбулаг зэрэг сумдууд хамгийн их сарлагтай ба сарлагийн хөөврийн гол нийлүүлэгч байх бүрэн бололцоотой. Судалгаанаас үзэхэд нэг сарлагаас 300-500 гр сайн чанарын хөөвөр самнаж бэлтгэвэл манай аймгийн хувьд 26,1 тонн хөөвөр бэлтгэн нийлүүлэх боломж харагдаж байгаа юм.

- Завхан аймаг

2007 оны байдлаар Завхан аймаг нь 63 100 толгой сарлагтай болсон бөгөөд тус аймгийн сарлаг үхрийн тоо сүүлийн 5 жилд тогтвортой өсч ирсэн юм. Сарлаг үхэр Их - Уул, Тосонцэнгэл, Идэр, Тэлмэн, Отгон, Шүлүүстэй зэрэг сумдад голчлон өсч байна. Тус аймагт сарлаг үхрийн хөөврийг самнаж ашиглаж заншаагүй учраас үхрийн хөөврийг зах зээлд нийлүүлэх, худалдан борлуулах асуудал дутагдалтай байлаа. Судалгаанаас харахад дундажаар нэг сарлагаас 360гр хөөвөр бэлтгэх боломжтой тус аймгийн хувьд нийт 63100 толгой сарлаг 2007 оны эцэст тоологдсон бөгөөд 20,5 тн сарлагийн сайн чанарын ноолуурлаг хөөвөр бэлтгэх боломжтой юм.

- Өвөрхангай аймаг

2007 оны статистик мэдээгээр Өвөрхангай аймаг нь нийтдээ **69722** сарлагтай болж өссөн бөгөөд тус аймгийн Бат Өлзий, Уянга, Зүүнбаянулаан болон Хужирт сумд сарлагийн тоо толгойгоороо бусад сумдаас тэргүүлдэг. Эдгээр сумдын малын тоог 2007 оны байдлаар үзвэл

№	Сарлаг бүхий зарим сумдын нэр	Нийт малын тоо	Сарлагийн тоо
1	Бат Өлзий	116092	19227
2	Уянга	187560	30533
3	Зүүнбаянулаан	119797	4702
4	Хужирт	168782	6401
	Нийт	592231	60863

Үүнээс эдгээр 4 сумдууд нийт 60683 толгой сарлагтай ба үүний 80% ийн хөөврийг ашиглана гэж үзвэл аймгийн хэмжээнд жилдээ 30,6-37,1 тонн хөөвөр бэлтгэх боломжтой гэж үзэж байна. Сарлаг судлаач эрдэмтдийн тооцоолсноор 1 сарлагаас 630 гр хөөвөр, 680 гр хялгас ашиглах бүрэн боломжтой.

## 6. Судалгааны арга зүй

Өртгийн сүлжээний судалгаа хийх 5 үе шаттай ерөнхий арга зүйг баримтлан бид дараах арга зүйг ашигласан сарлагийн хөөврийн дэд салбарын судалгааг явуулсан болно.

### 1-р үе шат: Дэд салбар/өртөгийн сүлжээний сонголт

Сарлагийн хөөвөр боловсруулан нэхмэл болон сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл нэмэгдэж байгаа нь сарлагийн хөөврийн эрэлтийг сүүлийн жилүүдэд эрс нэмэгдүүлж байна. Сарлагийн хөөвөр нь манай малчдын өрхийн орлогод тийм ч их хувийг эзэлж чаддаггүй боловч худалдан авагч, боловсруулагчдын ялангуяа экспортод гаргаж болох бүтээгдэхүүн гэдэг утгаараа сонирхол татсан бүтээгдэхүүн юм. Нөгөө талаар манай малчдын нэлээд хэсэг нь сарлагийн хөөврөө авч ашиглаж чадахгүй байгаа ба борлуулалтын суваг бий болсон тохиолдолд сарлагийн хөөврийг самнах, хяргах зэргээр ашиглаж өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж байгаа юм. Судалгаанд хамрагдсан дээрх 4 аймгийн малчдын хувьд сарлагийг самнаж ашиглах нь шинэ боломж юм. Тиймээс сарлагийн хөөврийн дэд салбарыг сонгосон болно.

### 2-р үе шат: Дэд салбар/өртөгийн сүлжээний судалгаа

- Сарлагийн хөөврийн үйлдвэрлэл, борлуулалттай холбоо суурь мэдээлэлүүдийг судлах /аймгуудын сарлагийн тоо толгой, хөөвөр бэлтгэлийн хэмжээ, нэгжээс ашиглаж буй хөөврийн хэмжээ, хөөврийн чанар/ Статистикийн газрын мэдээнүүд, Мал аж ахуйн хүрээлэнгээс явуулсан эрдэм шинжилгээний тайлан бусад холбогдох эх үүсвэрүүдийг ашиглан 5 жилийн дунджаар гаргасан
- Сарлагийн хөөвөр бэлтгэж буй сувгуудын талаархи судалгааг малчид, ченжүүд болон зарим нэг үйлдвэрийн төлөөлөгчдөөс санал асуулгын хуудсаар судалгаан дээр үндэслэн гаргасан
- Малчдад тохиолдож буй бэрхшээлийг дөрвөн аймгийн хөөвөр ихээхэн бэлтгэдэг сумдын малчдын дунд санал асуулга авах, ярилцлага хийх замаар,

малчид, үйлдвэрлэгчдэд тохиолдож буй бэрхшээлийг уулзалт ярилцлага зохион байгуулах, санал асуулга авах замаар тодорхойлсон

### *3-р үе шат: Арилжааны буюу зах зээлийн шийдлүүдийг тодорхойлох*

Арилжааны буюу зах зээлийн шийдлүүдийг тодорхойлохын тулд малчдад тохиолдож буй бэрхшээлийг санал асуулга, ярилцлага хийх замаар илрүүлэн үйлдвэрлэл болон борлуулалттай холбоотой бэрхшээлүүд гэж ангилсан ба тэрхүү бэрхшээлүүдийг даван гарахтай холбогдох шийдлүүдийг тодорхойлсон болно.

Шийдлүүдийг дараах үндсэн 6 бүлэгт хувааж тодорхойлсон болно:

- Сарлагийн хөөврийн ашиг тусын талаар мэдээлэл
- Үйлдвэрлэл/Технологи
- Дэд бүтэц
- Зах зээл/борлуулалт
- Үнэ
- Санхүү

### *4-р үе шат. Шийдлүүдийн үнэлгээ*

Арилжааны шийдлүүдийг тодорхойлсны дараа тэдгээр шийдлүүдийг дараах үзүүлэлтүүдээр үнэлэн эрэмбэлсэн:

- Тухайн шийдлийн үр нөлөө
- Тухайн шийдлийг хэрэгжүүлэх боломж

Шийдэл тус бүрийг эдгээр үзүүлэлтээр үнэлэхдээ 5 онооны системийн ашигласан ба хэмгийн үр нөлөө өндөртэй, хэрэгжүүлэх боломжтой шийдлүүдийг 5 оноо, хамгийн үр нөлөө багатай эсвэл хэрэгжүүлэхэд хүндрэлтэй шийдлүүдийг 0 оноогоор үнэлж нэгтгэсэн болно.

### *5-р үе шат: Хөтөлбөрийн оролцоо буюу хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох*

Хамгийн үр нөлөө өндөртэй, хэрэгжих боломжтой шийдлүүдийн хувьд шийдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах боломжтой байгууллагуудыг тодорхойлсны үндсэн дээр Хөтөлбөрийн оролцоог тодорхойлсон болно.

## **7. Судалгааны нэгтгэл, үр дүн**

Эдгээр аймгуудын өртөгийн сүлжээний судалгаа хийгдсэнээр энэ салбарт бодитой оршиж буй бэрхшээлийг илрүүлэх, тогтвортой үр нөлөө өгөх зах зээлийн шийдлүүдийг илрүүлэн хэрэгжүүлэх замаар сарлагийн хөөврийн салбарыг хөгжүүлэхэд туслах чухал алхам болох юм. Ингэснээр энэхүү судалгааны тайлан нь хөтөлбөрийн зүгээс тэдгээр зах зээлийн шийдлийг тогтвортой хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэхэд баримтлах зарчмын баримт бичиг болох юм.

- Судалгаанд оролцогчдын талаар мэдээлэл



Судалгаанд Архангай аймгийн 6 сумын 57 хүн, Баянхонгор аймгийн 6 сумын 125 хүн, Завхан аймгийн 7 сумын 167 хүн, Өвөрхангай аймгийн 4 сумын 121 малчид, ченжүүд зэрэг нийт 470 хүн оролцсон.

### Хүснэгт 3. Судалгаанд оролцогчид

Аймаг	Судалгаанд оролцогчдын тоо	сарлагийн тоо				
		Нийт	тугал	бяруу	шүдлэн	ТОМ мал
Архангай	57	3084	1442	364	273	1005
Баянхонгор	125	6868		1562	1701	3605
Завхан	167	3473		1042	766	1665
Өвөрхангай	121	3984	808	723	564	1889
<b>Нийт</b>	<b>470</b>	<b>17409</b>	<b>2250</b>	<b>3691</b>	<b>3304</b>	<b>8164</b>

Судалгаанд оролцсон малчид нийт 17,409 толгой сарлагтай бөгөөд эдгээрийн 53,1% нь бага насны, үлдэх 46,9% нь буюу 8,164 толгой нь том мал байна.

- Сарлагийн хөөврийн үйлдвэрлэл, бэлтгэл



Судалгаанд оролцсон нийт малчдын 24,5% нь сарлагийн хөөврөө авдаггүй бол 75,5% хөөврөө авдаг ба хөөврөө авч байгаа малчдын 81,1% нь хяргаж, үлдэх 18,9% нь самнаж авдаг байна. Хөөврөө самнаж авч байгаа малчдын тоо Архангай аймагт хамгийн их, Баянхонгор, Өвөрхангай аймагт цөөн байдаг бол Завхан аймагт судалгаанд оролцсон малчдаас хөөврөө самнаж авдаг хүн байгаагүй байна. Харин сарлагийн хөөврөө жил бүр самнаж хэвшсэн эсэхийг тодруулахад судалгаанд оролцсон бараг бүх малчид үгүй гэсэн байна.

Судалгаанд оролцсон малчдын 12,6% нь нийт сарлагийнхаа 30 хүртэлх хувийг, 18,7% нь 30-60 хувийг, 10,4% нь 60-80 хувийг авдаг бол ердөө 4,9% нь нийт сарлагийнхаа 80-100 хувийг самнадаг байна. Архангай, Өвөрхангай аймгийн 23 малчид л бараг бүх сарлагаа самнадаг гэсэн байна. Нийт малчдын 2/3 нь бага насны нэг сарлагийг самнахад хагас цаг зарцуулдаг гэсэн бол бараг тал нь буюу 52,6% нь бүдүүн сарлагийг самнахад хагас цаг зарцуулдаг гэсэн байна.

### Хүснэгт 4. Сарлагаа самнадаггүй шалтгаан

Аймаг	сам байхгүй	хүн хүч хомс	сарлагийн хөөврийн үнэ хямд	борлуулах цэг байхгүй	самнах арга мэддэггүй
Архангай	17	10	16	2	2
Баянхонгор	9	30	92	26	14
Завхан	35	3	78		
Өвөрхангай		10	58	49	
<b>Нийт</b>	<b>61</b>	<b>53</b>	<b>244</b>	<b>77</b>	<b>16</b>



Малчдын хувьд сарлагаа самнадаггүй хамгийн гол шалтгаан нь сарлагийн хөөврийн үнэ хямд (51,9%), борлуулах газар байдаггүй (16,4%), сам байхгүй (13,0%), хүн хүч хомс (11,3%), самнах арга мэддэггүй (3,4%) зэрэг байна.

Нийт судалгаанд оролцсон малчдын 34,9% нь сарлаг самнах самтай бол 65,3% нь сам байхгүй гэсэн байна. Түүнчлэн 32,1% нь нэг сарлагаас ойролцоогоор 500 граммаас дээш хөөвөр авдаг гэсэн бол 24,5% нь тус бүр 200-300гр, 300-500гр хөөвөр авдаг гэсэн байна. Харин үлдсэн хэсэг нь сайн мэдэхгүй гэж хариулжээ.

- Сарлагийн хөөврийн зах зээлийн өнөөгийн байдал




Малчид сарлагийн хөөврийг бага хэмжээгээр зах зээлд нийлүүлэхээс гадна өөрсдийн хэрэгцээнд гэрийн оосор бүч хийх, утас ээрэх зэргээр мөн ашигладаг байна.

Нийт малчдын 22,6 % нь зах зээлд борлуулдаг, 70,6% нь гэрийн оосор бүч хийх, эсгийнд мөн утас ээрч нэхмэл эдлэл хийх зэргээр өөрсдийн

хэрэгцээнд ашигладаг бол үлдэх 12,3% нь ашигладаггүй хаядаг байна.

Судалгаанд оролцсон малчдын 46,2% нь сарлагийн хөөврөө орон нутгийн ченжүүдэд, 17,0% нь аймгийн ченжүүдэд, 3,8% нь Эрдэнэт, эсгийний болон ямар нэгэн үйлдвэрлийн газар нийлүүлдэг бол 4,0% ЭШХ (Архангай аймаг) борлуулдаг байна. Харин 28,9% өөр газар борлуулдаггүй байна.



Сарлагийн хөөврийн үнэ (2007 оны байдлаар)

Аймаг	Самнасан	Хяргасан
Архангай	2500-3000 төг	400-500 төг
Баянхонгор	1500-2000 төг	350-400 төг
Завхан	--	200-400 төг
Өвөрхангай	1800-2000 төг	600-800 төг
Дундаж	1500-3000 төг	200-800 төг


Нийт судалгаанд хамрагдсан малчдын 67,2% нь цаашид сарлагийн хөөврийн хэрэглээ нэмэгдэнэ гэж үзсэн байхад 10,2% үгүй, харин үлдэх 22,6% нь мэдэхгүй байна гэсэн байна.

## **8. Сарлагийн хөөврийн салбарын өртөгийн сүлжээний зураг**

Тиймээс сарлагийн хөөврийн салбарын өртөгийн сүлжээний судалгааг хийж сүлжээний ерөнхий зураглалыг гарган энэ салбарт оролцогчидын хэвтээ болон босоо сүлжээний хамаарал тэдгээрийн хоорондын уялдаа холбоо ямар шатанд хэрхэн өртөг нэмэгдэж байгаа, ямар бэрхшээл боломжууд байгааг илрүүлэн боломжит шийдлүүдийг тодорхойлон хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн оролцоог тодорхойлох зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн юм.

Судалгаанаас харахад сарлагийг тэжээдэг/эсвэл тарга тэвээрэг, сүүний болон махны гарцыг нэмэгдүүлэх үүднээс нэмэлт тэжээл хэрэглэдэг нэг ч малчин байхгүй байгаа бөгөөд тэжээж үзээгүй байна. Харин зудтай жилүүдэд бага насны буюу 1-2 настай сарлаг тэжээл иддэг харин нас гүйцсэн сарлаг тэжээл авдаггүй гэж зарим нэг малчид ярьж байсан. Ер нь цаашдаа малчид сарлагийг нэмэлт тэжээлээр тэжээж сурсан нөхцөлд малын тэжээл нийлүүлэгч нар малчдад хүрч үйлчлэх бололцоотой. Мөн одоогоор нэг ч малын тэжээл нийлүүлэгч сарлаг бүхий малчдад үйлчилгээ үзүүлээгүй байна. Түүнчлэн малчдын ихэнх нь сарлаг самнах аргаа сайн мэддэггүй байна. Иймд сарлагийн хөөврийн талаар /үнэ ханш, чанар гэх мэт/ мэдээллээр хангадаг, технологийн сургалт үзүүлдэг төв/байгууллага мөн үгүйлэгдэж байна.

### Сарлагийн хөөврийн дэд салбарын өртгийн сүлжээний зураглал



### 9. Сарлагийн хөөврийн дэд салбарын зураглалтай холбогдуулан хийх дүгнэлтүүд

- Сарлагийн хөөвөр үйлдвэрлэн борлуулж буй үндсэн сувгууд.

Сарлагийн хөөврийн өртгийн сүлжээний зургаас харахад үйлдвэрлэл, борлуулалтын үндсэн 4 шат дамжлага байна. Үүнд:

#### 1) Сарлагийн хөөвөр үйлдвэрлэгчид буюу малчид:

Эдгээр аймгуудад сарлаг бүхий 85,500 гаруй өрх байгаа бөгөөд тэдгээрийг сарлагийн хөөврөө самнаж бэлтгэдэг, хяргаж бэлтгэн борлуулдаг болон эсвэл өөрсдийн хэрэгцээнд ашигладаг, зарим өрх огт хэрэглэдэггүй гэж хуваан үзсэн. Сарлагийн хөөврийн үнэ хямд, борлуулах цэг байхгүй, хөөвөр хяргах самнах нь ажиллагаа ихтэй байдаг учир малчид хөөврөө борлуулахуйц хэмжээгээр авдаггүй нилээд хэсэг нь ахуйн хэрэглээний зүйл хийдэг байна. Үүнд хөөврөөр улавч, ууцавч, өвдгөвч, цүнх хийдэг ба заримдаа хөөврөө эсгийрүүлэн гудас, хөнжил хийдэг байна. Ихэнх сарлаг бүхий өрхүүд хошлон, тушаа зэрэг зүйл хийдэг. Хошлон, дээс, тушаа зэргийг зөвхөн сарлагийн хялгасаар буюу сарлагийн савгаар хийдэг.

## 2) Сарлагийн хөөврийн завсрын борлуулагчид буюу орон нутгийн ченжүүд

Орон нутгийн ченжүүд нь аймаг, сумын төвд ноолуур болон бусад төрлийн түүхий эдийн арилжаа эрхэлдэг томоохон ченжүүд болон тэдгээр түүхий эд бэлтгэн өгдөг ченжүүд гэсэн шатлалтай байдаг байна. Аль ч ченжийн хувьд сарлагийн хөөврийн үнэ бага, борлуулах цэг байдаггүй учир бусад түүхий эд цуглуулах далимаар авдаг ба зорьж очиж авдаггүй байна. Тэд малчдын гар дээрээс хөөрийг авч дараагийн шат дамжлагад хүргэх замаар ашиг олдог байна. Ерөнхийд нь сарлагийн хөөвөр авдаг ченжүүдийг сумын, аймгийн, хотын гэсэн 3 түвшинд авч үзэж болно. Сарлагийн хөөвөр боловсруулагч үйлдвэрүүдийн төлөөлөгч, агентууд эсвэл бэлтгэн нийлүүлэгч хоршоод энэ салбарт үгүйлэгдэж байна.

## 3) Хүлээн авагчид буюу үйлдвэрүүд, Улаанбаатар хотын ченжүүд

Орон нутгийн ченжүүд өөрсдийн бэлтгэн нийлүүлсэн хөөврөө бэлтгэн нийлүүлэх хоршоогоор болон шууд Улаанбаатарын ченж-д борлуулдаг. Жишээ нь Өвөрхангай аймагт "Сарлаг Эрдэнэ" ТББ ажилладаг ба 2007 онд орон нутгийн томоохон ченжүүдтэй хамтран 12 тонн сарлагийн **хяргасан** хөөврийг Бат Өлзий, Зүүнбаянулаан, Уянга, Тарагт сумдаас бэлтгэн Эрдэнэт ноолуур ХХК-д нийлүүлсэн байна. Үүнээс уг ТББ дангаараа 2,7 тонн **хяргасан** хөөвөр бэлтгэжээ. Энэхүү хөөвөр бэлтгэж байсан туршлага дээрээ үндэслэн жил 2008 онд 15 тонн **хяргасан** хөөвөр нийлүүлэхээр гэрээ хийгээд байна. Ер нь аль ч байгууллага дангаараа хөөвөр бэлтгэх боломжгүй байдаг ба заавал ченж нарын оролцоотой нийлүүлдэг байна. Завхан аймгийн хувьд судалгаанаас харахад 67% нь орон нутгийн 5% нь аймгийн ченжүүдээр хөөврөө дамжуулан борлуулдаг 1% нь орон нутагт байгаа эсгийний үйлдвэрт борлуулдаг бөгөөд 27% нь хөөврөө борлуулдаггүй байна. Хөөвөр худалдан авдаг ченжүүд бараг байдаггүй байна.

## 4) Хүлээн авагч буюу экспортлогчид, Улаанбаатарын үйлдвэрүүд

1990-д оноос эхлэн сарлагийн хөөврийг ашиглах туршилтуудыг нэхмэлийн хүрээлэнгээс хийж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд сарлагийн хөөврийн 20/2 утсаар хийсэн бүтээгдэхүүн зах зээлд эрэлттэй болсон байна. Уг утсыг сарлагийн хяргасан хөөврөөс гаргаж болох боловч 10%-ийн гарцтай байдаг тул үйлдвэрлэлд тохиромжгүй байдаг. Тиймээс самнасан хөөврөөс уг утсыг гарган авахад хамгийн тохиромжтой бөгөөд сарлагийн хөөврийн боловсруулах технологи сайжрахын хэрээр самнасан хөөврийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж байгаа юм. Сарлагийн хөөврийг ихэвчлэн Эрдэнэт ноолуур ХХК, Эрдэнэт хот дахь Натурал Альфа ХХК, Хатан Сүлжээ ХХК, Монгол Амикал, Говь ХХК зэрэг үйлдвэрүүд авч бүтээгдэхүүн хийдэг. Сарлагийн хөөврийг туршилтын журмаар боловсруулж зарим бүтээгдэхүүн хийсэн нь үр дүнгээ өгчээ. **Эдгээр үйлдвэрлэгчдийн өмнө тулгарч байгаа гол бэрхшээл нь түүхий эдийн буюу самнасан сарлагийн хөөврийн олдоц бөгөөд малчид сарлагийн хөөврөө самнаж авч сураагүй байгаа нь үйлдвэрлэлд болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байна.** Ерөнхийдөө судалгаанаас харахад сарлагийн хөөврийн анхан шатны боловсруулалтыг орон нутагт хийхэд нийт хөөврийн 30-40% нь үйлдвэрийн шаардлагад нийцэж өндөр үнээр борлуулагдан үлдсэн хэсэг нь гар аргаар бүтээгдэхүүн хийх түүхий эд болдог байна. Сарлагийн хөөвөр нь тэмээний ноосноос зөөлөн тул сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тохиромжтой ба Финлянд, Канад зэрэг өвлийн аялал жуулчлал сайн хөгжсөн оронд уг бүтээгдэхүүн экспортлох боломжийг манай үйлдвэрүүд судалж байгаа юм байна.

- Сарлагийн хөөврийн бэлтгэлийн боломжит хэмжээ

1. Судалгааны дүнгээс харахад малчид хөөврийн үнэ тогтвортой, худалдан авах цэгтэй бол сарлагийнхаа 60 хүртэл хувийг самнах боломжтой гэсэн байна. Тиймээс малчдын бэлтгэж болох хэмжээг нийт сарлагийн тоог нэг сарлагаас гарах хөөврийн гарцын хэмжээгээр үржүүлсний 60%-р тооцсон болно.
2. Ченжүүдийн хувьд сарлагийн хөөвөр гарах 4, 5-р саруудад ямааны ноолуур гарахтай давхацдаг тул төдийлөн хөөвөрлүү анхаараалаа хандуулж чаддаггүй. Ийм учраас нийт малчдын нийлүүлэх хөөврийн 40% -ийг л худалдан авч бэлтгэн нийлүүлэх боломжтой хэмээн тооцсон.
3. Малчдын нийлүүлэх хөөврийн ченжүүдийн бэлтгэсний үлдэгдэл 60 %- ийг бэлтгэх боломжтой. Учир нь үйлдвэрүүд үүгээрээ дагнаж үйл ажиллагаа явуулдаг болохоор илүү боломжтой гэж үзсэн. Гэхдээ харилцаа холбоо, мэдээлэл, үйл ажиллагааны уялдаа холбоо чухал болно.

Хүснэгт 5. Малчид ченжүүдийн бэлтгэн нийлүүлэх боломжит хэмжээ

№	Аймаг	Сарлагтай малчин өрхийн тоо	Сарлагийн тоо	Нэг сарлагаас авах сарлагийн хөөвөр	Нийт малчдын бэлтгэх боломжтой хэмжээ кг	Ченжүүдийн бэлтгэж болох хэмжээ кг	Үйлдвэрүүдийн бэлтгэж болох хэмжээ кг
1	Архангай	136,092	15356	400гр	32,662	13,065	19,597
2	Баянхонгор	87,092	5,018	400гр	20,902	8,361	12,541
3	Завхан	57.000			13,680	5,472	8,208
4	Өвөрхангай	69,722	60,683	630 гр	16,733	6,693	10,040
	Нийт				<b>83,977</b>	<b>33,591</b>	<b>50,386</b>

4. Иймээс дээрх аймгийн малчид нийт 84,0 тонн орчим сарлагийн хөөвөр бэлтгэх боломжтой бөгөөд үүний 34,0 тонныг ченжүүдээр, 50,0 тонныг нь боловсруулах үйлдвэрүүд бэлтгэж авах бололцоотой гэсэн урьдчилсан таамаглалыг энэхүү судалгааны үндсэн дээр дэвшүүлж байна. Өнгөрсөн жил боловсруулах үйлдвэрүүд **НИЙТ** 10,0 тонн сарлагийн хөөвөр бэлдэж авсан бол энэ жил 15,0-17,0 тонн болгон нэмэгдүүлэх зорилт тавих боломжтой юм.

- Сарлагийн хөөврийн дэд салбарын бэрхшээл ба боломжит шийдлүүд

Ангилал	Бэрхшээлүүд	Арилжааны шийдлүүд
Мэдээлэл	Сарлагийн хөөврийн үнэ цэнийг малчид мэддэггүйгээс хөөврөө авдаггүй	1. Сарлаг самнах, самнасан хөөврийн ач тусыг малчдад ойлгуулах, ашиглах талаар мэдээлэл түгээх 2. Малчдыг идэвхжүүлэх, сарлагийн хөөврөөр хийсэн бүтээгдэхүүнийг малчдад сурталчлан таниулах
	Малчид сарлагийн хөөвөр боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагыг мэддэггүйгээс хяргаж авах нь түгээмэл байдаг	3. Боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагууд, сарлагийн хөөврийг бэлтгэх, ангилах сургалт явуулах
Үйлдвэрлэл/Технологи	Малчдын ихэнх нь сарлагийг хэрхэн самнах технологийн талаар мэдлэг байхгүй. Яг хэдийд самнах болон самнасан, хяргасан хөөврийн ялгаа, ашиг тусын талаар мэдлэг байхгүй	4. Сарлагийн хөөврийн самналт болон гарцыг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулах

	Сарлаг нь ерөнхийдөө эмнэг догшин шинжтэй амьтан учраас тэднийг барьж хүлэх зэрэгт ихээхэн цаг хугацаа болон хүн хүч шаарддаг, Хөөвөрлөхөд ажиллагаа ихтэй	5. Малчид малаас авч буй ашиг шимийг нэмэгдүүлэх үүднээс шинэ санаа гаргах, орчин үеийн арга технологи турших, ашиглах
	Сарлаг самнах сам байхгүй	6. Сарлаг самнах зориулалтын самаар хангах, зах зээлд нийлүүлэх
Дэд бүтэц	Сарлаг уулархаг нутгаар амьдардаг учраас зах зээлээс алслагдмал, зам бартаа ихтэй	7. Малчдад ойр худалдааны цэг байгуулах
	Зам харилцаа, холбоо муу ба сарлаг бүхий сумдын малчид сумаас хол, гар утсанд холбогдохгүй газар нутагладаг учир хөөвөр ашиглалтын талаар сүүлийн үеийн мэдээлэл авч чадахгүй байгаа ба үнийн хэлбэлзлэлийг ч мэдэхгүй байгаа	8. Үүрэн телефоны сүлжээг сайжруулах
	Орон нутгийн хэмжээнд сарлагийн хөөврийг боловсруулах үйлдвэр байхгүй.	9. Төвлөрсөн томоохон хот, суурин газруудын боловсруулах үйлдвэрүүд орон нутагт салбараа нээх
Зах зээл/борлуулалт	Сарлагийн хөөврийг худалдан авах малчдад аль болох ойр нэгдсэн цэг буюу арилжааны төв аймаг сумын төвүүдэд байхгүй	10. Сарлагийн хөөвөр авч бүтээгдэхүүн хийдэг үйлдвэр аж ахуйн газруудтай орон нутгийн ченжүүдийг холбох, гэрээ хийх, сарлагийн хөөврийн тогтсон хугацаанд тогтмол худалдан авдаг гэрээт ченжүүдийг бий болгох, тэднийг урамшуулах, дэмжих
	Дан ганц сарлагийн хөөврийн худалдааг дагнан, тогтмол хийдэг худалдан авагч, ченж байхгүй	
	Тодорхой зах зээл байхгүй	
	Сарлагийн хөөвөр гарах үеэр ямааны ноолуур ид гарч эхэлдэг учир малчид, ченжүүд анхаарал тавьдаггүй.	11. Малчидтай тохиролцсон үндсэн дээр нэгдсэн зохион байгуулалтайгаар ажилгүй иргэдээр сарлагыг самнуулж тохирсон хөлсийг нь өгөх
	Малчид үйлдвэрлэгчдийн хоорондын харилцаа холбоо байхгүй байгаа	12. Үйлдвэрийн газрууд өөрийн агентийг малчдад ойр газар ажиллуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний сурталчилгааг сайн хийх
Үнэ	Сарлагийн хөөврийн үнэ маш хямд Хөөврийн үнэ багатай байдлаас шалтгаалан малчид сарлагаа хөөвөрлөдөггүй	13. Сарлагийн хөөврийг зөвхөн самнаж авах, тодорхой үйлдвэрлэгч, боловсруулагч нартай гэрээ хийж нийлүүлэх, зах зээлд боломжит үнээр нийлүүлэх, үнийг нэмэгдүүлэх зорилгоор дуудлага худалдаа болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
	Малчид өөрсдөө сарлагийн хөөврийн үнэ ханшийг тогтоож чаддаггүй	14. Дуудлага худалдаа болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулж малчдыг өргөнөөр оролцуулах
	Зах зээлд ямар үнэтэй байгааг яг нарийн мэддэггүй	15. Үнэ ханшийн нэгдсэн тогтолцоотой болох, мэдээллийг малчдад тогмол хүргэх мэдээллийг хэрэгслийг ашиглах ХБМ-үнэ ханшийн мэдээлэлд оруулах
	Сарлагийн хөөвөр нь улирлын чанартай борлогддог.	16. Сарлагийн хөөвөр худалдан авалтыг тогтворжуулах
Санхүү	Сарлагийн хөөвөр бэлтгэл нь улирлын чанартай байдаг тул үйлдвэрүүд түүхий эдээ нөөцлөх бэлэн мөнгөний хомсдолтой	17. Түүхий эдээ бэлтгэх хөнгөлөлттэй зээл олгох

• Боломжит шийдлүүдийн үнэлгээ

Ангилал	Арилжааны шийдлүүд	Тухайн шийдлийн үр нөлөө	Тухайн шийдлийг хэрэгжүүлэх боломж	Нийт үнэлгээ
Мэдээлэл	1. Сарлаг самнах, самнасан хөөврийн ач тусыг малчдад ойлгуулах, ашиглах талаар мэдээлэл түгээх	Сарлагийн хөөврийг самнаж ашиглахын давуу талыг олж мэдсэнээр малчдад сарлагаа самнах болон бүтээгдэхүүн хийж ашиглах сонирхол бий болно. Ингэснээр самнасан сарлагийн хөөврийн нийлүүлэлт нэмэгдэн үндэсний шинэ бренд бүтээгдэхүүн бий болно.  (5 оноо)	Хөөвөр самнах сургалтаар энэ талын мэдээллийг түлхүү оруулах боломжтой.  Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглаж мэдээлэл түгээх, ялангуяа ХБМ сонин зэрэгт нийтлэл бичих боломжтой  Түүнчлэн боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөгчид, аймгийн ХХААГазар, сум багийн удирдлагууд, БДБ-ын гишүүдтэй хамтран орон нутгийн хэвлэл мэдээлэл, зарлалын самбар болон аман ухуулгыг ашиглан тогтмол хугацаанд чанартай сурталчилгаа хийх боломжтой. (5 оноо)	10 оноо
	2. Малчдыг идэвхжүүлэх, сарлагийн хөөврөөр хийсэн бүтээгдэхүүнийг малчдад сурталчлан таниулах	Малчдын сарлагийн хөөврийг үнэлэх үнэлэмж нэмэгдэж, орлогын шинэ боломжийг олж харах, сарлагийн хөөврөө бэлтгэн нийлүүлж сурна.  (5 оноо)	Сарлагийн хөөврөөр өөрсдийн боломжийг ашиглан гар аргаар бүтээгдэхүүн (майк, оймс, өмд, бээлий гэх мэт) үйлдвэрлэх технологийн сургалтыг зохион байгуулж бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой. (5 оноо)	10 оноо
	3. Боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагууд, сарлагийн хөөврийг бэлтгэх, ангилах сургалт явуулах	Сарлагийн хөөвөр бэлтгэх, ангилах сургалт явуулснаар малчид боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагад нийцсэн хөөвөр бэлтгэж зах зээл дэх хамгийн өндөр үнээр нийлүүлэх боломжтой болох юм. (5 оноо)	Боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөгчидтэй хамтран сургалтын модуль боловсруулан орон нутгийн БДБ-аар дамжуулан малчдад сургалт явуулах боломжтой (5 оноо)	10 оноо

Үйлдвэрлэл/Технологи	4. Сарлагийн хөөврийн самналт болон гарцыг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулах	Сарлагийн хөөвөр самналт болон гарцыг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байуулсанаар боломжит хэмжээгээр хөөврийг бэлтгэж зах зээлд нийлүүлэх боломжтой болно. Сарлаг самнах нь ихэнх малчдын хувьд нилээд шинэ зүйл учраас энэ сургалт чухал шаардлагатай гэж болно. (5 оноо)	Боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөгчид, орон нутгийн үржлийн албаны мэргэжилтэнүүд, Монгол Сарлаг нийгэмлэгтэй хамтран орон нутгийн БДБ болон ХАА-н Альянсийн сургагч багш нарыг өндөр түвшинд бэлтгэх, чадваржуулах, бэлтгэгдсэн багш нараар дамжуулан малчдад сургалт явуулах, бүлгээр хамтран самнах ажлыг зохион байгуулах боломжтой (5 оноо)	10 оноо
	5. Малчид малаас авч буй ашиг шимийг нэмэгдүүлэх үүднээс шинэ санаа гаргах, орчин үеийн арга технологи турших, ашиглах	Аль болох уламжлалт аргаас татгалзаж богино хугацаанд бүтээмж ихтэй сарлаг хөөвөрлөх зориулалтын цахилгаан болон механик сам, машин, тоног төхөөрөмжтэй болох нь цаашдын тогтвортой байдалд чухал нөлөөтэй юм. Түүнчлэн уяа баглаагүйгээр самнах арга технологийг нэвтрүүлэх хэрэгтэй. Ингэснээр малчид сарлагаа тогтмол хөөвөрлөдөг болохоос гадна цаг хугацаа, гар ажиллагааг ихээхэн хэмнэж хөөврийг бүрэн самнах боломжтой болно. (5 оноо)	Манай хөтөлбөр, ХХААЯам болон ШУЯ-тай хамтран энэ талын тоног төхөөрөмж зохион бүтээх уралдааныг шинэ санаа гаргагч, зохион бүтээгч нарын дунд зохион байгуулах, ЭШ- ний байгууллагаар дамжуулан технологи нэвтрүүлэх боломжтой юм. (1 оноо)	6 оноо
	6. Сарлаг самнах зориулалтын самнах хангах, зах замаар зээлд нийлүүлэх	Сарлаг самнах замыг зах зээлд хүрэлцэхүйц хэмжээгээр нийлүүлснээр сарлагийн хөөврийн нийлүүлэлт нэмэгдэнэ (5 оноо)	Монгол сарлаг нийгэмлэг, бусад сарлагийн хөөвөр боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран сарлаг самнах сам үйлдвэрлэн малчдад нийлүүлэх боломжтой (5 оноо)	10 оноо
Дэд бүтэц	7. Малчдад ойр худалдааны цэг байгуулах	Одоогоор ихэнх малчид орон нутгийн ченжүүдэд түүхий эдийг нийлүүлдэг ба малчдад ойр худалдааны цэгтэй болсноор малчид бага зардлаар хөөврөө борлуулах боломжтой болно. (1 оноо)	Орон нутгийн ченжүүд, боловсруулах үйлдвэрүүдийн болон онцгой худалдан авагчдын төлөөлөгчидтэй уулзалт ярилцлага зохион байгуулж агентуудыг ажиллуулах (1 оноо)	2 оноо
	8. Үүрэн телефоны сүлжээг сайжруулах	Үнийн мэдээлэл болон бусад мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой болно. (3 оноо)	Үүрэн телефоны оператор компаниудын боломжоор хязгаарлагдана. (1 оноо)	3 оноо



	9. Төвлөрсөн томоохон хот, суурин газруудын боловсруулах үйлдвэрүүд орон нутагт салбараа нээх	Сарлагийн хөөврөн бүтээгдэхүүнийг таниулах, зах зээлд нийлүүлэх бололцоотой болохоос гадна малчдад сарлагийн хөөврөө борлуулах байнгын зах зээлтэй болох боломж нээгдэнэ. (5 оноо)	Орон нутагт боловсруулах үйлдвэрүүд салбараа нээх нь цахилгаан, ус зэрэг дэд бүтэц, түүний хангамжаас шалтгаалах ба бага оврын боловсруулах үйлдвэрийн ашигтай ажиллах боломжоор хязгаарлагдана (1оноо)	6 оноо
Зах зээл/борлуулалт	10. Сарлагийн хөөвөр авч бүтээгдэхүүн хийдэг үйлдвэр аж ахуйн газруудтай орон нутгийн ченжүүдийг холбох, гэрээ хийх, сарлагийн хөөврийн тогтсон хугацаанд тогтмол худалдан авдаг гэрээт ченжүүдийг бий болгох, тэднийг урамшуулах, дэмжих	Үйлдвэр аж ахуйн газар, орон нутгийн ченжүүдийн хамтын ажиллагаа сайжирч, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн чанар, хэмжээ нэмэгдэх сайн талтай ба тухайн үйлдвэр түүхий эдийн нөөцөөр тасралтгүй хангагдах боломж бий болно. (4 оноо)	Онцгой худалдан авагч, боловсруулах үйлдвэрүүд, ченжүүдийн бэлтгэн нийлүүлсэн хөөврийн хэмжээ, чанар болон гэрээний биелэлтийг дүгнэж боловсруулагчдын зүгээс тодорхой урамшууллын систем бий болгон ажиллах боломжтой ч зуучлагчаар дамжуулан түүхий эдийг нийлүүлэх болон худалдан авах сонирхол малчдад болон үйлдвэрийн газарт бага байдаг (1 оноо)	5 оноо
	11. Малчидтай тохиролцсон үндсэн дээр нэгдсэн зохион байгуулалтайгаар ажилгүй иргэдээр сарлагыг самнуулж тохирсон хөлсийг нь өгөх			
	12. Үйлдвэрийн газрууд өөрийн агентыг малчдад ойр газар ажиллуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний сурталчилгааг сайн хийх	Үйлдвэрийн газрууд өөрийн агентыг ажиллуулснаар малчид боловсруулах үйлдвэрүүдийг шаардлагыг сайн ойлгох, түүнд тохирсон сарлагийн хөөвөр бэлтгэх боломжтой болохоос гадна үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний сурталчилгааг сайн хийснээр сарлагаа самнах сэдлийг төрүүлэх ач холбогдолтой (4 оноо)	Томоохон үйлдвэрийн газруудын шийдвэрээс шалтгаална (1 оноо)	5 оноо

Үнэ	13. Сарлагийн хөөврийг зөвхөн самнаж авах, тодорхой үйлдвэрлэгч, боловсруулагч нартай гэрээ хийж нийлүүлэх, зах зээлд боломжит үнээр нийлүүлэх, үнийг нэмэгдүүлэх зорилгоор дуудлага худалдаа болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Малчид сарлагийн хөөврийг илүү өндөр үнээр борлуулах боломжтой зах зээлтэй холбосноор сарлагийн хөөврийн сүлжээ бий болоход сайн нөлөө үзүүлнэ. Сарлагийн самнасан хөөврийг боломжит өндөр үнээр худалдан авах үйлдвэрлэгч боловсруулагч нартай холбосноор малчид малын түүхий эдийг бүрэн ашиглаж орлого нэмэгдэнэ, боловсруулагчдын түүхий эдийн олдоц нэмэгдэнэ (5 оноо)	Онцгой худалдан авагч, боловсруулах үйлдвэрүүд, ченжүүд, малчид оролцсон дуудлага худалдааг аймагт бүрт зохион байгуулах боломжтой (5 оноо)	10 оноо
	14. Дуудлага худалдаа болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулж малчдыг өргөнөөр оролцуулах			
	15. Үнэ ханшийн нэгдсэн тогтолцоотой болох, мэдээллийг малчдад тогтмол хүргэх мэдээллийг хэрэгслийг ашиглах ХБМ-үнэ ханшийн мэдээлэлд оруулах	Үнийн хэлбэлзэл, ханшийн талаар бодит мэдээллийг тогтмол авснаар малчид орлогоо урьдчилан тооцох, нэмэгдүүлэх шийдвэр гаргахад суралцах ба ингэснээр сарлагийн хөөврийн ашиглалт нэмэгдэх ач холбогдолтой (3 оноо)	ХБМ болон сарлаг ихтэй өндөрлөг газруудад G- mobile ийн сүлжээгээр болон бусад сувгуудаар үнийн мэдээллийг тогтмол хүргэх боломжтой ч оператор комданиудын боломжоор хязгаарлагдана (2 оноо)	5 оноо
	16. Сарлагийн хөөвөр худалдан авалтыг тогтворжуулах	Сарлагийн хөөвөр худалдан авалтыг тогтворжуулбал малчид сарлагийн хөөврөө байнга борлуулах боломжтой болох юм (4 оноо)	Сарлагийг жилд нэг удаа самнах ба эрэлт ихтэй тул бэлтгэсэн хөөвөр богино хугацаанд борлогддог (1 оноо)	5 оноо
Санхүү	17. Түүхий эдээ бэлтгэх хөнгөлөлттэй зээл олгох	Ченжүүд хангалттай эргэлтийн хөрөнгө бүрдүүлэх боломжтой болсноор сарлагийн хөөврийг малчдаас бэлэн мөнгөөр худалдан авах боломжтой болно. Ингэснээр малчдын бэлэн мөнгөний хомсдол багасах ач холбогдолтой хэдий ч сарлагийн хөөврийн борлуулалтын орлого нийт орлогын багахан хувийг эзэлж байна (2 оноо)	Арилжааны банкууд эргэлтийн хөрөнгийн болон худалдааны зээлүүдийг санал болгож байгаа ч хүү хугацааны хувьд төдийлөн тохиромжтой биш байдаг. (3 оноо)	5 оноо

• **Үр нөлөө бүхий шийдлүүдийг хэрэгжүүлэхэд Хөтөлбөрийн оролцоо**

Боломжит шийдлүүдийг үнэлж хамгийн үр нөлөө ихтэй, хэрэгжүүлэх боломж сайтай шийдлүүдийг нэгтгэвэл:

- a) Малчдад сарлаг самнах, самнасан хөөврийн ач тусыг таниулах, малчдыг идэвхжүүлэх
- b) Боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагууд, сарлагийн хөөврийг бэлтгэх, ангилах, самналт болон гарцыг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулах сургалт зохион байгуулж малчдыг идэвхжүүлэх, сарлаг самнахад сургах
- c) Сарлаг самнах зориулалтын самаар хангах, зах зээлд нийлүүлэх
- d) Сарлагийн хөөврийг зөвхөн самнаж авах, тодорхой үйлдвэрлэгч, боловсруулагч нартай гэрээ хийж нийлүүлэх, зах зээлд боломжит үнээр нийлүүлэх, үнийг нэмэгдүүлэх зорилгоор дуудлага худалдаа болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулах

Дээрх шийдлүүдийг хэрэгжүүлэх арга зам:

№	Зорилго	Үйл ажиллагаа	Хүлээж буй үр дүн	Хэрэгжүүлэх арга зам	Хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүд
1	Боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагууд, сарлагийн хөөврийг бэлтгэх, ангилах, самналт болон гарцыг нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулах сургалт зохион байгуулж малчдыг идэвхжүүлэх, сарлаг самнахад сургах	Боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагыг судлах, нэгтгэх Сарлаг самнах сургалтын хөтөлбөр Сарлаг самнах сургалтын гарын авлага бэлтгэх Боловсруулах Орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх, сургах	Аймаг бүрт 7-35 орон нутгийн багш бэлтгэгдэнэ  Аймаг бүрт 7-8 сумын малчдад сарлаг самнах сургалт явуулна	Монгол сарлаг нийгэмлэгээр дамжуулан тэдэнтэй хамтран ажилладаг томоохон боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөгчидтэй хамтрах	Бэлтгэгдсэн орон нутгийн сургагч багш нар Орон нутгийн сургагч багш нарын явуулсан сургалтын тоо
2	- Малчдад сарлаг самнах болон самнасан хөөврийн эдийн засгийн ач холбогдлыг таниулах, малчдыг идэвхжүүлэх	Бэлтгэгдсэн багш нар малчдад сарлаг самнах сургалт явуулах	Сургалтаар нийт 1300 малчдад хүрнэ	Монгол сарлаг нийгэмлэгийн боловсруулсан сургалтын хүрээнд	Сургалтанд оролцсон малчдын тоо Сургалтанд оролцсон малчдын сарлаг самналтын хувь
3	Сарлаг самнах зориулалтын самаар хангах, зах зээлд нийлүүлэх	Аймаг бүрт 300 ширхэг сам бэлтгэж хүргүүлэх	Сарлаг самнах зориулалтын самыг сургалтанд оролцсон малчдад нийлүүлснээр сарлаг самналтын хувь нэмэгдэнэ	Самыг орон нутгийн сургагч багш нар болон БДБ-т хандивлах Орон нутгийн сургагч багш нар болон БДБ самыг борлуулна.	Сам худалдан авсан малчдын тоо Малчдын сарлаг самналтын хувь
4	Сарлагийн хөөврийг зөвхөн	Аймаг бүр сарлагийн	Үзэсгэлэн худалдаагаар	Монгол сарлаг нийгэмлэгээр	Самнасан хөөврийн

	самнаж авах, тодорхой үйлдвэрлэгч, боловсруулагч нартай гэрээ хийж нийлүүлэх, зах зээлд боломжит үнээр нийлүүлэх, үнийг нэмэгдүүлэх зорилгоор дуудлага худалдаа болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	хөөврийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	нийт 15,0-17,0 тонн сарлагийн хөөвөр борлуулах	дамжуулан ноос боловсруулах үйлдвэрүүдийг үзэсгэлэн худалдаанд урих	хэмжээ Борлуулсан хөөврийн дүн Үзэсгэлэн худалдаанд оролцсон үйлдвэрүүдийн тоо
--	---	--	--	---	--

## 10. Дүгнэлт

Сарлагийн хөөврийн дэд салбарын судалгааг манай орны хамгийн их сарлагтай Архангай, Баянхонгор, Завхан, Өвөрхангай аймгуудад судалгааны дараах аргыг ашиглан явууллаа. Үүнд:

- Статистикийн газрын мэдээнүүд, Мал аж ахуйн хүрээлэнгээс явуулсан эрдэм шинжилгээний тайлан бусад холбогдох эх үүсвэрүүдийг ашиглан сарлагийн хөөврийн үйлдвэрлэл, борлуулалттай холбоотой суурь мэдээлэлүүдийг цуглуулах
- Сарлагийн хөөвөр бэлтгэж буй сувгуудын талаархи судалгааг малчид, ченжүүд болон зарим нэг үйлдвэрийн төлөөлөгчдөөс санал асуулгын хуудсаар авч гаргасан
- Малчдад сарлагийн хөөврөө бэлтгэж, борлуулахад нь тохиолдож буй бэрхшээлүүдийг дээрх аймгуудийн хөөвөр ихээхэн бэлтгэдэг сумдын малчдын дунд санал асуулгын хуудас бөглүүлэх, ярилцлага хийх замаар тодорхойлсон бол сарлагийн хөөврийн дамжин нийлүүлэгчид болон үйлдвэрлэгчдэд тохиолдож буй бэрхшээлүүдийг уулзалт, ярилцлага зохион байгуулах, санал асуулга авах замаар тодорхойлсон

Судалгааны үр дүнд сарлагийн хөөврийн бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын сувгийн зураглалыг гарган, бэлтгэх боломжтой сарлагийн хөөврийн хэмжээг тооцооллоо. Судалгаанаас үзэхэд сарлаг бүхий малчид нь **хөөврөө самнаж бэлтгэн борлуулдаг, хяргаж бэлтгэн борлуулдаг, зөвхөн өрхийн дотоод хэрэгцээнд ашигладаг, мөн хөөврийг огт авч хэрэглэдэггүй** гэсэн 4 өөр ангилалд хуваагддаг байна.

Сарлагийн хөөврийн гол борлуулалт нь орон нутгийн ченжүүдээр дамжин явагддаг юм байна. Боловсруулах үйлдвэрүүдийн сарлагийн хөөврийн эрэлт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа ч түүхий эд бэлтгэн нийлүүлдэг малчидтай хамтран ажиллах, тэднийг урамшуулах, сарлагийн хөөврийн бэлтгэн нийлүүлэлтийн талаар ямар нэгэн дорвитой үйл ажиллагаа огт хийгээгүй байна. Нөгөө талаар сүүлийн жилүүдэд сарлагийн хөөврийн үнэ хямд байсан, эрэлт бага, борлуулах цэг байхгүй, зах зээл хязгаарлагдмал байснаас гадна сарлагийн хөөвөр хяргах, самнах нь ажиллагаа ихтэй байдаг учраас ихэнх малчид хөөврөө зах зээлд борлуулахуйц хэмжээгээр авдаггүй байсан нь судалгаагаар тогтоогдлоо. Түүнчлэн малчид сарлаг самнах арга, боловсруулах үйлдвэрүүдийн шаардлагыг мэддэггүйгээс тэр бүр

сарлагаа самнадаггүй байна. Малчдын ихэнх хэсэг нь сарлагийн хялгас/савагаар гэр ахуйн хэрэглээний эд зүйл хийдэг байна.

Судалгаанаас гарсан тооцоолол дээр үндэслэх дээрх 4 аймгийн хувьд нийт 84,0 тонн орчим сарлагийн хөөвөр бэлтгэх боломжтой гэсэн урьдчилсан тооцооллыг хийсэн бөгөөд энэ жил /2008/-д нийт 15,0-17,0 тонн сарлагийн хөөвөр бэлтгэх зорилготой ажиллах зөвлөмжийг гаргалаа.

Дотоодын үйлдвэрүүдэд сарлагийн хөөврөөр өндөр чанартай бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлж эхэлж байна. Энэ нь түүхий эдийн эрэлтийг нэмэгдүүлж байгаа ч нийлүүлэлт харьцангуй маш бага байгаа нь харагдаж байна. Иймд 1) малчдад сарлаг гэдэг малын ач тусыг ойлгуулах, тоо толгойг нэмэгдүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, ялангуяа сарлагийн хөөврийг бэлтгэн нийлүүлэх талаар нэгдсэн бодлого, томоохон компани ажил болгох нь чухал байна. 2) Дотоодын үйлдвэрийн газрууд сарлагийн хөөврөөр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдээ малчдад сурталчилах. 3) Дотоодын үйлдвэрийн газрууд малчдаас шууд хөөвөр худалдан авах компани ажлыг жил бүр зохион байгуулдаг болох. Хэрэв ингэж чадвал орон нутагт байгаа, сарлаг бүхий малчид сарлагаас дан ганц мах сүүг ашиглах биш хөөврийг ямааны ноолуурын дайтай ашиглан өрхийн орлогоо өндрөөр нэмэгдүүлэх бүрэн боломжтой байгаа юм.

***Цаашид сарлаг өсгөх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх улсын бодлого үгүйлэгдэж байгаа нь уг судалгааны явцад харагдсан.***

Энэхүү судалгаа болон судалгааны зөвлөмж нь сарлагийн хөөврийн дэд салбарыг хөгжүүлэхэд чухал алхам боллоо.